

САНХҮҮГИЙН ХЯНАЛТ ШАЛГАЛТ ХИЙСЭН ДҮНГИЙН ТУХАЙ

НЭГ. ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ЗОРИЛГО

Булган аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, аудитын албаны 2019 оны хяналт шалгалтын нэгдсэн төлөвлөгөө аймгийн засаг даргын баталсан 2019 оны 06 сарын 12-ны өдрийн 1/12 дугаар удирдамжийн дагуу Булган аймгийн Хялгант тосгоны Улсын тэргүүний Хараацай цэцэрлэгийн 2018 оны санхүү, аж ахуйн үйл ажиллагаанд Монгол Улсын Төсвийн тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулиуд болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан бусад эрх зүйн актуудын хэрэгжилтийг шалгаж, зөрчил дутагдал илэрсэн тохиолдолд холбогдох хуулийн дагуу шийдвэрлэх, аливаа эрсдлээс урьдчилан сэргийлэх, цаашид давтан гаргахгүй байх талаар мэргэжил арга зүйн заавар, зөвлөгөө өгөхөд чиглэгдлээ.

ХОЁР. ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН БҮРЭЛДЭХҮҮН, ХУГАЦАА

Санхүүгийн хяналт шалгалтын улсын ахлах байцаагч Б.Баттулга, Аудитор П.Пүрэвжав нар 2019 оны 06 сарын 13-ны өдрөөс 06 сарын 17 хүртэл хугацаанд шалгалтыг хийв.

ГУРАВ. ШАЛГАЛТАНД ХАМРАГДСАН АСУУДЛУУД

Цэцэрлэгийн 2018 оны касс, харилцах дансны гүйлгээг санхүүгийн анхан шатны баримттай тулган шалгасны зэрэгцээ цалин хөлс, урамшуулал, албан томилолтын бодолт, олголт, шатахууны олголт түүний зарцуулалтыг автомашины замын хуудастай тулгаж, бараа материалын худалдан авалт, зарцуулалт, эд хөрөнгийн тооллого тооцоо бодолт, санхүү, төсвийн ил тод байдлын хэрэгжилт, Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт зэрэг хяналт шалгалтын удирдамжид заагдсан асуудлуудыг бүрэн хамруулан нягтлан бодогч Ё.Эрдэнээ, нярав С.Мөнхцацрал нарыг байлцуулан төлөвлөгөөт хяналт шалгалтыг хийв.

ДӨРӨВ. ШАЛГАЛТАНД ХАМРАГДСАН ОБЪЕКТЫН ТАЛААРХ ТОВЧ МЭДЭЭЛЭЛ

Булган аймгийн Хялгант тосгоны Улсын Тэргүүний “Хараацай” Цэцэрлэг нь 2018 оны хичээлийн жилд хүүхэд нэг бүрийг хөгжүүлэх сургалтын цөм хөтөлбөрийг

хэрэгжүүлэх, 2018-ны хичээлийн жилд тус цэцэрлэг нь сургуулийн өмнөх боловсролын сургалтын цөм хөтөлбөрийг хэрэгжүүлэх, СӨББ-ын орчны стандартыг мөрдөж бага насны хүүхдийг хөгжүүлэх, төлөвшүүлэхэд үйл ажиллагаагаа чиглүүлэн ажилласан байна. Цэцэрлэгийн эрхлэгчийн 2018 оны 01 дугаар тушаалаар Эрхлэгч 1, Нярав 1, Тогооч 3, Үйлчлэгч 1, Арга зүйч 1, Дуу хөгжмийн багш 1, Сантехникч 1, Сахиул 1, Жижүүр 4, Багш 7, Туслах багш 7 нийт 29 хүний орон тоотой үйл ажиллагаа явуулж байна. Тус цэцэрлэгийн 1-р гарын үсгийг Д.Амгалан 2-р гарын үсгийг Ё.Эрдэнээ нар зурж орлого, зарлагын гүйлгээг хийж, хөрөнгө мөнгийг захиран зарцуулж иржээ.

ТАВ. ӨМНӨХ ШАЛГАЛТЫН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ

Дотоод хяналт шалгалт хийсэн боловч баримт байхгүй байсан.

ЗУРГАА. ШАЛГАЛТЫН ЯВЦАД ХИЙГДСЭН АЖИЛ, ШАЛГАЛТАНД ХАМРАГДСАН АСУУДЛУУД

6.1. Санхүүгийн эх үүсвэрийн бүрдүүлэлт, зарцуулалтын талаар: 2018 онд төсөвт зардлыг 404096.1 төгрөгөөр төлөвлөж, нэмэлт санхүүжилтээр 1988.5 мянган төгрөг нийт 406084.6 мянган төгрөгийг зарцуулсан байна. Ажиллагсдын цалин хөлсөнд 223329.8 мянган төгрөгийг төлөвлөснөөс 225085.9 мянган төгрөг олгосон. Нийгмийн даатгалын шимтгэлд 26800.0 мянган төгрөгийг төлөвлөснөөс 26614.3 мянган төгрөг, хангамжийн бараа материалын зардалд 1276.0 мянган төгрөг, норматив зардалд 54268.8 мянган төгрөг, эд хогшил урсгал засварт 4358.8 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардалд 268.5 мянган төгрөг, бараа үйлчилгээний зардалд 3768.6 мянган төгрөг, тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж 4986.0 мянган төгрөг, хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилсаны тэтгэмж 8418.6 мянган төгрөг зарцуулж 418.7 мянган төгрөг төсөвт төвлөрүүлсэн байна.

Цалин урамшууллын талаар: Хангал сумын Хялгант тосгоны захирагчийн 2017 оны 12 сарын 21-ний өдрийн Б/59 тоот захирамжаар Эрхлэгч Д.Амгаланд төсвийн ерөнхий захирагчтай байгуулсан 2017 оны төрийн албан хаагчийн үр дүнгийн гэрээний биелэлт 95%-тай дүгнэгдэж 1 сарын үндсэн цалин болох 711230 төгрөг, Цэцэрлэгийн эрхлэгчийн 2018 оны 03 сарын 21-ний өдрийн 03 тоот тушаалаар ур чадварын нэмэгдэл 10%-аас 25%-иар буюу 863,9 мянган төгрөг, мөн оны 6-р сарын 18-ний өдрийн эрхлэгчийн 13 тоот тушаалаар үр дүнгийн урамшуулал 30%-аас 60%-иар буюу 7877.9 мянган төгрөг, аймгийн Засаг даргын 2018 оны 05 сарын 09-ний өдрийн Б/46 тоот захирамжаар ур чадварын нэмэгдэлийг 1 сарын 1-ээс 7 сарын 31-ний өдрийг хүртэл 25%-иар буюу 1008.6 мянган төгрөг, аймгийн Засаг даргын 2018 оны 9 сарын 25-ний өдрийн А/574 тоот тушаалаар ур чадварын нэмэгдэлийг 7 сараас 12 сарыг дуустал 25%-иар буюу 1008.6 мянган төгрөг, эрхлэгчийн 2018 оны 05 сарын 25-ний өрийн 12 тоот тушаалаар ур чадварын нэмэгдэлийг 10%-аас 20%-иар буюу 1045.1 төгрөг, эрхлэгчийн 2018 оны 09 сарын 16-ний өдрийн 19 тоот тушаалаар үр дүнгийн урамшуулалыг 35%-иас 55%-иар буюу 6491.4 мянган төгрөг, эрхлэгчийн 2018 оны 10 сарын 23-ний өдрийн Б/20 тоот тушаалаар ур чадварын нэмэгдэлийг 20%-иас 25%-иар буюу 1168.7 төгрөг, эрхлэгчийн 2018 оны 11 сарын 19-ний өдрийн 29 тоот тушаалаар 10%-иас 15%-иар буюу 371.3 мянган төгрөг, эрхлэгчийн 2018 оны 12 сарын 13-ний өдрийн Б/33 тоот тушаалаар ур чадварын нэмэгдэлийг 10%-иас 25%-иар буюу 1765.3 мянган төгрөг, мөн оны 12 сарын 13-ний өдрийн Б/32 тоот тушаалаар үр дүнгийн урамшуулал 30%-аас 60%-иар буюу 6236.5 төгрөгийг тус тус бодож олгосон байна.

6.2. Үндсэн хөрөнгийн хөдлөл өөрчлөлт: 2018 он

№	Нэр	Мөнгөн дүн /төгрөгөөр/			
		Эхний үлдэгдэл	Орлого	Зарлага	Эцсийн үлдэгдэл
1	Барилга байгууламж	481693800	99289302	225426840	355554261
2	Машин тоног төхөөрөмж	45033575	429900	2504700	42958775
3	Тавилга, эд хогшил	26033575	563000	4357240	22486046
5	Бусад үндсэн хөрөнгө	17695068		611412	17083655
6	Биет бус хөрөнгө		16210000		16210000
	Дүн	570702729.40	116490202.50	232900193.58	454292738.32

2018 оны эхэнд 570702.7 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө дээр төсвийн хөрөнгөөр 116490.4 мянган төгрөгийн хөрөнгө авснаас 563.0 төгрөгийн ширээ, 16210.0 газрын үнэлсэн, 429.9 мянган төгрөгийн хэвлэгч худалдан авсан. 232900.2 мянган төгрөгийн зарлага гарснаас Аймгийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2018 оны 12 сарын 27-ний өдрийн 110 тоот тогтоолоор Хялгант тосгоны Цулхар хэсэгт байрлах “Хараацай” цэцэрлэгийн харъяа 115055.4 төгрөгийн өртөгтэй ашиглалтын хугацаанд байгуулсан элэгдэл 83959.3 мянган төгрөгийн “Нахиа” бүлгийн байр “Булган-Мээж” ХХК-ийн БИЗУ-100 маркийн 38844.4 мянган төгрөгийн өртөгтэй, элэгдэлээрэй өртгөө нөхсөн 2 ширхэг халаалтын тогоог.

Мөн 2504.7 мянган төгрөгийн машин тоног төхөөрөмж (1ш компьютер, 2ш хэвлэгч, 1ш ширээ, 1ш хөргөгч) акталсан байна. Тавилга эд хогшил 4357.2 мянган төгрөгний (1ш хивс, 1ш хөлдөөгч, 1ш телефон утас, 1ш индүү, 1ш даралтат хөгжим, 1ш ширээ, 1ш компьютерийн ширээ, 1ш өнгөт зурагт, 2ш махны машин, 1ш тоос сорогч, 1ш ус буцалгагч, 1ш будаа агшаагч, 3ш шкаф, 4ш хүүхдийн сандал,) тавилга эд хогшил акталсан байна.

Бусад үндсэн хөрөнгөнөөс 5ш хийлдэг тоглоом, 6ш соронзтой модон самбар, 6ш хөгжим, 2ш хүүхдийн ундаг машин зэрэг нийт 611.4 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө акталж оны эцэст 454292.7 мянган төгрөгний үндсэн хөрөнгө бүртгэгдсэн байна.

6.3. Бараа материалын хөдлөл өөрчлөлт:2018 он

№	Тайлангийн нэр	Мөнгөн дүн /төгрөгөөр/			
		Эхний үлдэгдэл	Орлого	Зарлага	Эцсийн үлдэгдэл
1	Эм боох материал	40000	40000		80000
2	Бэлэн бүтээгдэхүүн	2378206			2378206
3	Бичиг хэрэг	1714249	6724400	1032930	1912619

4	Аж ахуйн материал	24141025	6724400	4279100	26586325
5	Сэлбэг хэрэгсэл		15500	15500	
6	Түлш тослох материал		646100	646100	
7	Барилгын материалын засвар	3250000	6340744	7120372	2470372
8	Хүнсний материал	7612219	53395800	53832162	7175856
	НИЙТ ДҮН	39135699	68393844	66926164	40603378

2018 оны эхэнд 39135.6 мянган төгрөгний бараа материал дээр төсвийн хөрөнгөөр 68393.8 мянган төгрөгний бараа материал худалдан авч 66926.1 мянган төгрөгний зарлага гарч оны эцэст 40603.3 мянган төгрөгний бараа материал бүртгэгдсэн байна.

6.4. Өглөг, авлагын талаар: 2018 өглөг, авлага гараагүй байна.

6.5 Шилэн дансны талаар: Шилэн дансны тухай хуулийн дагуу шилэн дансны нэгдсэн системд 2018 төсөв гүйцэтгэлийн 49 мэдээлэл оруулхаас 1 мэдээлэл хоцроож, 48 мэдээлэлийг хугацаанд нь оруулсан. Хөрөнгө оруулалт, тендер худалтан авалтын 39 мэдээлэл оруулхаас 2 мэдээлэл хоцроож 37 мэдээлэл хугацаанд нь оруулсан байна.

ДОЛОО. ШАЛГАЛТААР ИЛЭРСЭН ЗӨРЧИЛ, ТҮҮНИЙ ШАЛТГААН, ЗӨРЧИГДСӨН ХУУЛЬ, ТОГТООМЖ

1. Орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан 3 багшид олгосон тэтгэмжид тушаал гаргаагүй.
2. Тушаал шийдвэрийн үндэслэлийг хууль эрх зүйн дагуу үг үсгийн алдаагүй гаргах.

НАЙМ. АВСАН АРГА ХЭМЖЭЭ, МЭРГЭЖЛИЙН ТУСЛАЛЦАА, ЗӨВЛӨГӨӨ ӨГСӨН БАЙДАЛ

Шалгалтын хугацаанд 2 албан тушаалтанд мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөв.

ЕС. ДҮГНЭЛТ

Монгол улсын Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.1, 13.5, 13.7 дахь /шинэчилсэн/ заалтууд, няравын тайлан гаргалт анхан шатны баримтын бүрдэлт сайн.

Эд хөрөнгийн тоололгын бүртгэл сайн хөтөлсөн байна. Санхүүгийн үйл ажиллагаандаа дотоод хяналтын хэрэгжилт сайн.

АРВАН НЭГЭН. ЦААШИД АНХААРАХ АСУУДАЛ

Тушаал шийдвэрийн үндэслэлийг хууль эрх зүйн дагуу үг үсгийн алдаагүй гаргах.

Монгол улсын нягтлан бодох бүртгэлийн тухай, төсвийн тухай хуулийг үйл ажиллагаандаа хэрэгжүүлж ажиллах

Санхүүгийн үйл ажиллагаандаа дотоодын хяналт шалгалтыг тогтмол хийж санхүүгийн сахилга хариуцлагыг дээшлүүлэх

